

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetsegm@audit.gov.mn">atartsetsegm@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 19 № 103

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 134 удаагийн нислэг хүлээн авч, 110 нислэгт бэлтгэл аэродромоор ажилласан байна.

Зорчигч үйлчилгээг сайжруулах зорилгоор VIP зорчигчийн танхим, хүүхдийн өрөөнд засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээг 3 жилийн хугацаатай сунгуулсан.

Албан ажлын хэрэгцээнд зарцуулах шатахуун нийлүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зохион байгуулж амжилтгүй болсон байна

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020286

Тайлант онд Иргэний нисэхийн Үндэсний төвөөс 47,518.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж хоорондын тооцоогоор шилжүүлсэн байна.

### **Бусад асуудал**

Иргэний нисэхийн Үндэсний төвтэй 2024 онд 10 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, гэрээг 95.1 хувьтай үнэлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГҮНЖИДМАА



**Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	25,163,446.94	<b>621,706.98</b>
1.1.2	Дансны авлага	128,982.00	3,128,807.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	182,724.59	1,516,211.60
1.1.6	Бараа материал	183,562,725.61	259,812,622.44
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>209,037,879.14</b>	<b>265,079,348.02</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,964,777,756.29	<b>12,139,770,750.64</b>
1.2.2	Биет бус хөрөнгө	2,915,220,438.80	<b>2,901,772,710.43</b>
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	15,243,325.59	<b>13,722,153.71</b>
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>15,895,241,520.68</b>	<b>15,055,265,614.78</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,104,279,399.82</b>	<b>15,320,344,962.80</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	110,716.43	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>110,716.43</b>	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>110,716.43</b>	-
2.3	Эздийн өмч	4,653,083,201.92	4,544,623,005.26
2.3.1	Өмч: - төрийн	2,899,940,000.00	2,899,940,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,753,143,201.92	1,644,683,005.26
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	30,896,665.48	19,196,665.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг	11,420,188,815.99	10,756,525,292.06
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>16,104,168,683.39</b>	<b>15,320,344,962.80</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,104,279,399.82</b>	<b>15,320,344,962.80</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

(төгрөгөөр)

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1.1.1</b>	<b>Борлуулалтын орлого</b>	<b>15,285,053.42</b>	<b>38,793,029.51</b>
	Буулт хөөрөлтийн орлого	13,857,313.82	19,555,723.36
	Буудлын хураамж	15,730.00	3,186,089.73
	Бүртгэлийн цэгийн орлого	16,000.00	372,756.00
	Үнэмлэх борлуулсны орлого	435,000.00	415,000.00
	Газрын техник үйлчилгээний орлого	82,000.00	14,040,180.00
	Шатахуун тээвэрлэлтийн орлого	879,009.60	405,280.42
	Үйл ажиллагааны бусад орлого	-	818,000.00
	<b>БОРЛУУЛАЛТЫН орлогын дүн</b>	<b>15,285,053.42</b>	<b>38,793,029.51</b>
<b>1.2</b>	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>2,161,764,804.09</b>	<b>2,410,327,379.07</b>
	Бичиг хэрэг	2,397,501.22	3,522,206.53
	Албан конторын зардал	107,272.75	1,059,818.13
	Шатахуун	65,472,048.52	91,747,703.19
	Үндсэн цалин	376,400,008.20	486,571,407.48

Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын  
хураангуй тайлан

	Илүү цаг	25,042,497.15	54,251,794.30
	Амралтын мөнгө	43,254,976.52	58,821,578.69
	Цалингийн бусад нэмэгдэл	178,282,713.28	218,300,388.40
	<b>Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн</b>	<b>622,980,195.15</b>	<b>817,945,168.87</b>
	Хоолны үнийн хөнгөлөлт	85,080,000.00	145,800,000.00
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	94,658,584.96	126,303,503.84
	Сэлбэг засвар-Барилга	39,431,543.21	48,631,726.17
	Сэлбэг засвар-Автомашин	23,214,406.25	30,863,965.83
	Сэлбэг засвар-Аэродром	39,267,095.30	10,602,131.20
	Сэлбэг засвар -ТТ	31,471,228.89	22,186,472.64
	<b>Сэлбэг засвар</b>	<b>133,384,273.65</b>	<b>112,284,295.84</b>
	Цахилгаан	30,753,263.47	33,368,888.79
	Дулаан	60,278,774.66	49,477,644.97
	Усны зардал	1,774,384.28	6,326,643.75
	Холбооны зардал	7,533,575.81	8,549,788.95
	<b>Ашиглалтын зардлын дүн</b>	<b>100,339,998.22</b>	<b>97,722,966.46</b>
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	906,073,885.35	859,819,282.81
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	17,794,558.35	13,447,728.37
	<b>Элэгдлийн зардлын дүн</b>	<b>923,868,443.70</b>	<b>873,267,011.18</b>
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	14,603,535.82	8,724,338.70
	Тээврийн хэрэгслийн татвар	385,909.09	714,256.00
	Хөрөнгийн даатгал	35,099,026.00	19,800,000.00
	<b>Татвар, даатгалын зардлын дүн</b>	<b>50,088,470.91</b>	<b>29,238,594.70</b>
	Хөдөлмөр хамгаалал	25,086,884.91	12,197,262.08
	Дотоод сургалтын зардал	-	120,000.00
	<b>Сургалтын зардлын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
	Дотоод томилолт	27,368,777.90	79,693,423.91
	<b>Албан томилолтын зардлын дүн</b>	<b>27,368,777.90</b>	<b>79,693,423.91</b>
	Харуул хамгаалалт	1,849,194.66	1,777,057.86
	Цэвэрлэгээний зардал	3,176,380.64	10,148,366.48
	Лабораторийн зардал	320,000.00	
	Зорчигч үйлчилгээний зардал	210,000.00	
	Гал команд	16,598,049.63	7,000,000.00
	Аудит баталгаажуулалтын зардал	-	
	Үйлдвэрлэлийн бусад зардал	8,778,727.27	500,000.00
<b>1.3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(2,146,479,750.67)</b>	<b>(2,371,534,349.56)</b>
<b>1.4</b>	<b>Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал</b>	<b>15,128,292.55</b>	<b>4,214,357.00</b>
	Цалингийн бусад нэмэгдэл	13,328,292.55	514,357.00
	Аудит баталгаажуулалтын зардал	1,800,000.00	3,600,000.00
	Бусад зардал		100,000.00
<b>1.5</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>(2,161,608,043.22)</b>	<b>(4,214,357.00)</b>
<b>2</b>	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>1,269,106,622.77</b>	<b>(2,375,748,706.56)</b>
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	1,347,191,768.51	1,656,049,702.11
	Бусад үйл ажиллагааны бус орлого	5,930,000.00	11,714,218.32
	Санхүүжилт орлого	1,238,300,000.00	1,549,189,321.42
	Систем хоорондын тооцоогоор орлого	97,803,708.17	88,601,157.94

**Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуулалтын олз	5,158,060.34	6,545,004.43
<b>2.6.2</b>	<b>Бусад үйл ажиллагааны бус зардал</b>	<b>78,085,145.74</b>	<b>53,549,716.13</b>
	Үйл ажиллагааны бус бусад зардал	480,402.01	390,000.04
	Тэтгэмж	500,000.00	7,175,000.00
	Түлшний хөнгөлөлт	1,000,000.00	2,400,000.00
	Банкны үйлчилгээний зардал	27,000.00	2,670.00
	Эмнэлэг үйлчилгээний зардал	-	5,406,000.00
	Систем хоорондын тооцоогоор зардал	56,644,957.93	38,151,046.09
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуулалтын гарз	19,432,785.80	
	Хүү торгуулын зардал		25,000.00
<b>2.3</b>	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн</b>	<b>1,269,106,622.77</b>	<b>1,602,499,985.98</b>
<b>3</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(892,501,420.45)</b>	<b>(773,248,720.58)</b>
<b>4</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(892,501,420.45)</b>	<b>(773,248,720.58)</b>
<b>5</b>	<b>Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>(892,501,420.45)</b>	<b>(773,248,720.58)</b>
<b>6</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(892,501,420.45)</b>	<b>(773,248,720.58)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(төгрөгөөр)**

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,260,493,555.66</b>	<b>1,606,051,167.42</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	21,116,227.66	36,927,535.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	328,172.00	378,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,238,300,000.00	1,549,189,321.42
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	749,156.00	19,556,311.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,244,690,300.54</b>	<b>1,244,690,300.54</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	599,205,326.14	862,688,176.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	175,364,041.93	233,866,176.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	314,072,800.80	400,800,068.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	36,333,641.04	41,202,667.39
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	72,218,264.63	86,924,769.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	35,099,026.00	
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	12,397,200.00	5,110,470.10
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,803,255.12</b>	<b>(24,541,160.40)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>15,803,255.12</b>	<b>(24,541,160.40)</b>
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>15,803,255.12</b>	<b>(24,541,160.40)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,360,191.82</b>	<b>25,163,446.94</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>25,163,446.94</b>	<b>622,286.54</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/**

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	2,899,940,000.00	1,753,143,201.92	30,896,665.48	11,421,313,815.99	16,105,293,683.39
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	-	-
2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	2,899,940,000.00	1,753,143,201.92	30,896,665.48	11,421,313,815.99	16,105,293,683.39
Залруулсан үлдэгдэл	2,899,940,000.00	1,753,143,201.92	30,896,665.48	11,421,313,815.99	16,105,293,683.39
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(773,248,720.58)	(773,248,720.58)
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(108,460,196.66)	(11,700,000.00)	108,460,196.66	(11,700,000.00)
2024 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	2,899,940,000.00	1,644,683,005.26	19,196,665.48	10,756,525,292.07	15,320,344,962.81

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан / төгрөг/**

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>1,773,774,800.00</b>	<b>1,611,451,596.38</b>	<b>162,323,203.62</b>	<b>90.8</b>
<b>НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,773,774,800.00</b>	<b>1,611,451,596.38</b>	<b>162,323,203.62</b>	<b>90.8</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,749,814,700.00</b>	<b>1,592,249,096.38</b>	<b>157,565,603.62</b>	<b>91.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,073,902,800.00</b>	<b>1,022,289,587.79</b>	<b>51,613,212.21</b>	<b>95.2</b>
Үндсэн ба нэмэгдэл цалин	844,507,400.00	1,022,289,587.79	177,782,187.79	121.1
Унаа хоолны хөнгөлөлт	185,118,400.00		185,118,400.00	-
Гэрээт ажлын цалин	44,277,000.00		44,277,000.00	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>142,405,200.00</b>	<b>72,217,358.40</b>	<b>70,187,841.60</b>	<b>50.7</b>
Тэтгэврийн даатгал	91,281,700.00	72,217,358.40	19,064,341.60	79.1
Тэтгэмжийн даатгал	10,739,000.00		10,739,000.00	-
ҮОМШ-ийн даатгал	15,678,100.00		15,678,100.00	-
Ажилгүйдлийн даатгал	3,228,300.00		3,228,300.00	-
Эрүүл мэндийн даатгал	21,478,100.00		21,478,100.00	-
<b>Байр ашиглалттай холбоотой</b>		<b>106,020,822.49</b>		

**Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

<b>тогтмол зардал</b>	<b>115,796,000.00</b>		<b>9,775,177.51</b>	<b>91.6</b>
Гэрэл, цахилгаан	39,720,000.00	32,093,652.49	7,626,347.51	80.8
Түлш, халаалт	70,000,000.00	69,900,000.00	100,000.00	99.9
Цэвэр, бохир ус	6,076,000.00	4,027,170.00	2,048,830.00	66.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>116,907,500.00</b>	<b>117,145,793.00</b>	<b>238,293.00</b>	<b>100.2</b>
Бичиг хэрэг	3,336,200.00	3,167,000.00	169,200.00	94.9
Тээвэр, шатахуун	95,845,300.00	95,810,000.00	35,300.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,000,000.00	9,273,593.00	273,593.00	103.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	4,181,500.00	181,500.00	104.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,726,000.00	4,713,700.00	12,300.00	99.7
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>166,703,400.00</b>	<b>162,965,420.00</b>	<b>3,737,980.00</b>	<b>97.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	<b>87,996,100.00</b>	<b>84,335,560.00</b>	<b>3,660,540.00</b>	<b>95.8</b>
Тоног төхөөрөмж	21,916,200.00	21,748,800.00	167,400.00	99.2
Автомашин	22,404,700.00	19,322,800.00	3,081,900.00	86.2
Аэродром	22,007,700.00	21,929,860.00	77,840.00	99.6
Гал унтраах зардал	21,667,500.00	21,334,100.00	333,400.00	98.5
Хөдөлмөр хамгааллын зардал	28,707,300.00	28,682,400.00	24,900.00	99.9
Урсгал засвар	50,000,000.00	49,947,460.00	52,540.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>75,472,900.00</b>	<b>75,721,350.00</b>	<b>248,450.00</b>	<b>100.3</b>
Дотоод албан томилолт	75,472,900.00	75,721,350.00	248,450.00	100.3
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,626,900.00</b>	<b>35,888,764.70</b>	<b>22,738,135.30</b>	<b>61.2</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,859,000.00	-	2,859,000.00	
Харуул, хамгаалалтын зардал	4,500,000.00	3,402,000.00	1,098,000.00	75.6
Үл хөдлөх хөрөнгийн татвар	19,999,900.00	8,396,398.70	11,603,501.30	42.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,936,000.00	3,600,000.00	336,000.00	91.5
Даатгалын үйлчилгээ	19,948,600.00	19,800,000.00	148,600.00	99.3
Тээврийн хэрэгслийн татвар	1,103,500.00	687,696.00	415,804.00	62.3
Газрын төлбөр	6,099,900.00		6,099,900.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	180,000.00	2,670.00	177,330.00	1.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,070,100.00</b>	<b>8,996,500.00</b>	<b>73,600.00</b>	<b>99.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	9,070,100.00	8,996,500.00	73,600.00	99.2
Сургалт семинар	<b>1,100,000.00</b>	<b>200,000.00</b>	<b>900,000.00</b>	<b>18.2</b>

Дотоод сургалт	1,100,000.00	200,000.00	900,000.00	18.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,790,000.00</b>	<b>10,006,000.00</b>	<b>3,784,000.00</b>	<b>72.6</b>
<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг</b>	<b>13,790,000.00</b>	<b>10,006,000.00</b>	<b>3,784,000.00</b>	<b>72.6</b>
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	8,350,000.00	4,600,000.00	3,750,000.00	55.1
Эмчилгээний төлбөр	5,440,000.00	5,406,000.00	34,000.00	99.4
<b>НИЙТ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,773,774,800.00</b>	<b>1,276,020,535.00</b>	<b>497,754,265.00</b>	<b>71.9</b>
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>61,500,000.00</b>	<b>37,720,535.00</b>	<b>23,779,465.00</b>	<b>61.3</b>
Агаарын навигацийн үйлчилгээний орлого		-	-	
Буулт, хөөрөлтийн орлого	18,000,000.00	36,927,535.00	18,927,535.00	205.2
Зорчигч үйлчилгээний орлого	12,000,000.00	415,000.00	11,585,000.00	3.5
Бусад орлого	31,500,000.00	378,000.00	31,122,000.00	1.2
<b>ТӨВӨӨС САНХҮҮЖИХ ДҮН</b>	<b>1,712,274,800.00</b>	<b>1,238,300,000.00</b>	<b>473,974,800.00</b>	<b>72.3</b>

### Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулга хийгээгүй болно.

Залруулагдаагүй нийт 11,190.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11,190.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрч 11,190.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Албан шаардлага

1. Зарцуулагдаагүй бодитоор байгаа 11,190.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зарлагдаж данснаас хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бодитоор байгаа бараа материалыг орлогод авах албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт:

1. Сангийн сайдын баталсан анхан шатны бүртгэлийн маягт шаардах хуудсыг тухай бүр, бүрэн бичихгүйгээр халаалтын зуухны ээлж хүлээлцэх хуудасны дагуу нүүрсийг шууд зарлагадсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ын 2.6 Шаардах хуудас "Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн шаардах хуудсыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан анхан шатны бүртгэлийн маягт болох шаардах хуудсаар зөвшөөрөл авч зарцуулж байх.

2. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нярвын үлдэгдлийг тоолсон нь эд хариуцагчийн бүртгэл, комиссын илтгэх хуудсаар нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг хууль журмын дагуу үнэн зөв, чанартай хийж, нотлох баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сангийн сайдын баталсан анхан шатны бүртгэлийн маягт шаардах хуудсыг тухай бүр, бүрэн бичихгүйгээр халаалтын зуухны ээлж хүлээлцэх хуудасны дагуу нүүрсийг шууд зарлагдсан.	1	-	-	-	-	-	1	-
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нярвын үлдэгдлийг тоолсон нь эд хариуцагчийн бүртгэл, комиссын илтгэх хуудсаар нотлогдохгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Зарцуулагдаагүй бодитоор байгаа 11,190.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зарлагдаж данснаас хассан.	1	-	-	-	1	11,190.0	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>11,190.0</b>	<b>2</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨАА		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			